

ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГАД ЭЛССЭНЭЭР МОНГОЛ УЛСЫН БАЙР СУУРЬ ӨСӨН БЭХЖЛЭЭ

*Янь Тао**

5 жил хэлэлцээ хийсний эцэст, Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад /ДХБ-ВТО/ элсэж, түүний 130 дах гишүүн орон боллоо. Дэлхийн худалдааны байгууллагад элссэн нь Монгол Улсад олон улсын байр сууриа зузаатгахад чухал ач холбогдолтой болсон юм. Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн болсоноор Монгол Улс Их гүрнүүдийн нэг адил дэлхийн худалдааны байгууллагын бодлого тогтооход оролцох эрхтэй, бусад улстай харилцан ойлголцлолоо нэмэгдүүлж, өөрийн дуу хоолойг улам бүр өргөнөөр илэрхийлж болох боллоо.

Монгол Улс ДХБ-д элссэний дараа, үүрэг хүлээхийн төлөө, онцгой бүтээгдэхүүнээс гадна импортын гаалийн татварыг хамгийн өндөр 20%-иас хэтрэхгүй тогтоож, зарим барааг “тэглэсэн гаалийн татвартай” болгох бодлого баримтлав. Монгол Улсын одоо хэрэгжүүлж буй гаалийн татвар нь хөгжиж буй орны хувьд ярих юм бол харьцангуй доогуур, дэлхийн худалдааг либералчилахад хувь нэмрээ оруулж байгаа юм. “Тэглэсэн гаалийн татварын бодлого” нь тухайн газрын хэрэглээнд цохилт өгч, богино хугацааны дотор бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хангалтгүй асуудлыг шийдвэрлэсэн ч сөрөг нөлөө гарсаар байна.

Сурвалжлагчийн харсанаар, Улаанбаатарын том жижиг дэлгүүрүүдэд худалдаалагдаж буй арьс шир, ноосон эдлэлээс бусад ихэнхи бараа тухайлбал хоол хүнс, хувцас, цахилгаан хэрэгсэл, эм тариа, гоо сайхны бараа, тоглоом зэрэг нь Европ, Хятад, Япон, Солонгос, Турк гэх мэт орнуудаас импортоор орж ирсэн байна. Энд худалдаалагдаж буй хятадын бүтээгдэхүүний үнийг хятадын дотоодын үнэтэй харьцуулахад хамгийн бага нь 1-2 дахин үнэтэй байсан. Яагаад бага ашигтай борлогдож байна вэ? Сурвалжлагч энэ асуудлыг тодруулахаар зарим нэг дэлгүүрийн хүмүүстэй уулзаж ярилцахад, гаалийн татвар нь үнийн өсөлтөнд тийм их нөлөө үзүүлээгүй харин тээвэрлэлтийн зардал өндөр, мөн хүмүүсийн худалдан авах чадвар хязгаарлагдмал учир үнэтэй л

* Янь Тао - “Хуанчю шибао” (Ертөнцийн цаг) сонины Монголд суугаа тусгай сурвалжлагч

зарахгүй бол ашиг бага юм гэж ярилаа.

Улаанбаатарын гудамжинд хаа сайгүй бенц, форд, тоёота, хьондай зэрэг импортын автомашинууд байдгаас Солонгос, Японых нэлээд элбэг юм. Гэвч эдгээр импортоор орж ирсэн автомашинууд нь хуучин бөгөөд зарим нь нэлээд элэгдсэн. Гадаад үзэмжийг нь харахад эдгээр автомашинууд нь маш их хуучирсан, моторын дуу чимээ ихтэй бөгөөд утаа нь орчин тойрныг бохирдуулж байна. Жолоочийн ярьж байгааг сонсоход эдгээр хуучин автомашинууд ихэнх нь 100.000-150.000 км явсан учраас 2000 ам доллараар худалдан авч болох бөгөөд татвар нь бага, өөр бусад зардал үгүй юм.

Монгол Улс нь уламжлалт мал аж ахуйн орон бөгөөд ДХБ-д элссэнээр гадаадын компаниуд монголын зах зээлд аажим аажмаар нэвтрэн орж, хувцас, мэдээлэл зэрэг монголд байхгүй салбарыг эзэлж байгаа ба ДХБ-д элссэн нь монголын дотоодын эдийн засагт цохилт өгөхгүй билээ. Гэвч монголын хөрөнгө оруулалтын орчин тийм ч таатай бус учраас гадаадын хөрөнгө оруулагчид олон биш юм. Монголын хамгийн том хамтарсан үйлдвэр бол Монгол-Оросын хамтарсан Эрдэнэт үйлдвэр бөгөөд энэ нь Монгол Улс ДХБ-д элсэхээс өмнө байгуулагдсан. ДХБ-д элссэний дараа Хятад болон Солонгосын хувцасны компаниуд Монгол улс нь Америк, Европын орнуудад бүтээгдэхүүнээ экспортлоход хязгаарлалт байдаггүйг анзаарч, үйлдвэрээ монголд байгуулан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортлож, монголд зарж борлуулдаггүй байна. Монголын Засгийн газар монголд үйлдвэр байгуулахыг дэмжиж, ийм байдлаар ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэж байна.

Монгол Улс одоо түүхий эд болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг голчлон экспортолдог ба мах махан бүтээгдэхүүнийг ОХУ-д бага хэмжээгээр нийлүүлдэг байна. Монгол Улсын худалдааны гол түнш Орос, Хятад нь ДХБ-д элсэж орсоноор Монголын эдийн засагт их нөлөө үзүүлэх нь тодорхой юм гэж Монгол Улс үзэж байна.

Хятад хэлнээс орчуулсан Н.Отгонсүрэн

Хятадын “Хуанчю шибао” сонины
2001 оны 5-р сарын 11-ний дугаар